



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 6145

Улаанбаатар хот

Сувиллын хөнгөлөлт олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан "2017-2018 оны Хамтын гэрээ"-ний 5.5 дахь заалт, өндөр настан болон ажилтны өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн "Ар жанчивлан" рашаан сувилалд 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл 10 хоног сувилуулсан Турбин-хими цехийн өндөр настан Намнангийн Нямдорж, ЦДХХА-н цехийн өндөр настан Санжмятавын Оюунчимэг нарт тус бүр 100000 /Нэг зуун мянга/ төгрөг, "Далд засал" сувилалд 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 10 хоног сувилуулсан Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн эдийн засагч Лхагваагийн Оюун-Эрдэнэ /100557/-д 200000 /Хоёр зуун мянга/ төгрөг, 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 6 хоног сувилуулсан тус хэлтсийн ахлах нягтлан бодогч Гүндсамбуугийн Нямдолгор /100813/-т 120000 /Нэг зуун хорин мянга/ төгрөгийн сувиллын хөнгөлөлтийг тус тус олгосугай.

2. Сувиллын хөнгөлөлтөд олгох 200000 /Хоёр зуун мянга/ төгрөгийг өндөр настан, групптэй хүмүүсийн сувиллын хөнгөлөлтийн зардлаас, 320000 /Гурван зуун хорин мянга/ төгрөгийг ажилчдын нийгмийн эрүүл мэнд, сувиллын хөнгөлөлтийн зардлаас тус тус тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.2019

360000703